

АГУУЛГА

Товчилсон үгсийн жагсаалт 2

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 3-4

Тайланг бэлтгэсэн:

Булган аймгийн
Төрийн аудитын газар

Тэргүүлэх Аудитор

Д.Анхбаяр

Аудитын менежер

Ж.Энхцоодол

Ахлах аудитор

Г.Ганбаатар

Аудитор

П.Мөнхтуяа

2018 оны 4 дүгээр сар

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зййл байвал 70342495 дугаарын утас, 70342580 дугаарын факсаар харилцана уу.

Цахим хаяг:
Bulgan@audit.gov.mn

Бүлэг А. Аймагт хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалт нь орон нутгийн хэрэгцээ шаардлагыг үндэслэн төлөвлөгдсөн боловч барилгын ажил удааширалтай, гэрээгээр хүлээсэн үүргээ талууд хангалтгүй биелүүлсэн, захиалагчийн хяналтыг аймгийн ГХБХБГ хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

А.1.Төсөл арга хэмжээний төлөвлөлт хуулийн шаардлагад нийцсэн байна. 5

А.2. Захиалагчийн болон зохиогчийн хяналтыг барилга угсралтын ажлын явцад үр нөлөөтэй хэрэгжүүлээгүй, ажлын гүйцэтгэлийг хугацаанд нь бодитой үнэлж, баталгаажуулаагүй байна. 5

А.3. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд талуудын хүлээх эрх, үүрэг, хариуцлагыг бүрэн тусгасан боловч гэрээгээр хүлээсэн үүргээ 2 тал хэрэгжүүлээгүй байна. 5

А.4. Гүйцэтгэгч байгууллага барилга угсралтын ажлыг батлагдсан зураг төсөл, барилгын норм дүрмийн дагуу гүйцэтгээгүй байна. 5

А.5. Ажлын гүйцэтгэл тодорхойгүй байхад санхүүжилт олгосон байна. 6

А.6. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг захиалагчийн хяналт муутай, гүйцэтгэгч үүргээ биелүүлээгүй байхад олгосон байна. 6-8

Билэг Б. Тэшиг сумын сургуулийн барилгыг Барилгын хөгжлийн төвийн магадлалаар оруулж 2017 оны 82/2017 тоот дүгнэлтээр барилгын ажлыг үргэлжлүүлэн цаашид ашиглах боломжтой гэсэн. Харин аудитын дүгнэлтээр “Төмөр хүлэг” ХХК нь гэрээний дагуу ажлаа хийгээгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй байна.

Б.1. Дуусаагүй орхигдсон,Барилга байгууламжийн хэрэгцээ шаардлага хэвээр байна. 8

Б.2.Дутуу орхигдсон барилгын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх замаар цаашид ашиглах боломжтой гэсэн дүгнэлтийг Барилгын хөгжлийн төвөөс гаргасан байна. 9

Б.3.Барилгын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх шаардлагагүй гэж дүгнэсэн барилга байгууламж байхгүй боловч, олон жил удааширсан, ажилд холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй байна. 9

Ді гнэлт

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР

ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ИХ	Иргэний хууль
БТХ	Барилгын тухай хууль
ҮАГ	Үндэсний Аудитын газар
УТХО-ДБ	Улсын төсвийн хөрөнгө оруулалт-дуусаагүй барилга
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
АЗД	Аймгийн Засаг дарга
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалт газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

2018.04.12.

Булган

1.Аудитын зорилт:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн, дуусаагүй орхигдсон барилга, байгууламжийн ажлыг хугацаанд нь хэрэгжүүлээгүй шалтгааныг тодорхойлж, барилга, байгууламжийн одоогийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, аудитын дүн, дүгнэлт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитын зорилтыг хангахын тулд дараахь үндсэн чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн, дуусаагүй барилга, байгууламжийн орхигдсон үндэслэл, шалтгааныг тогтоосон эсэх,
- Дуусаагүй орхигдсон барилга, байгууламжийн өнөөгийн нөхцөл байдал, цаашид үргэлжлүүлэн ашиглах боломжийг тодорхойлсон эсэх,

2.Хамрах хүрээ:

Аудитад 2010 оноос хойш улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэж, баригдаж эхэлсэн боловч санхүүжилт нь зогссон, барилга угсралтын ажил дуусаагүй, ашиглалтанд ороогүй, Монгол улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хуулийн 1 дүгээр хавсралтаар Монгол улсын төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад тусгагдаагүй барилгуудыг хамруулсан. Мөн орон нутагт уг төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд болох аймгийн Өмчийн газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Санхүү төрийн сангийн хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ажлын гэрээ, гүйцэтгэл, мэдээ, тайланд тулгуурлан хэрэгжүүлэгчдийн үйл ажиллагааг хамруулсан.

3.Аудитын арга зүй:

Аудитын явцад холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, холбогдох судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглахаас гадна Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын гарын авлагад дурдсан аудитын арга зүйг мөрдөж, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

4.Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.

- Монгол улсын 2017 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт
- Төсвийн тухай хууль
- Иргэний хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Барилгын тухай хууль

- Дээрх хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрхийн актууд
- Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаал “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”
- Барилга угсралтын ажлын үлгэрчилсэн дүрэм 2015 он

5. Аудит хийх хугацаа

Аудитын төлөвлөлт, хөтөлбөрийг хийх, арга зүйг боловсруулах, гүйцэтгэх, тайлагнах, холбогдох баримт материалыг бүрэн бүрдүүлж нотлох баримтыг хангах, олон нийтэд мэдээлэх зэрэгт 2018 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн ажлын 27 хоногт багтаан гүйцэтгэлээ.

6. Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг аймгийн Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хянан удирдан, ахлах аудитор Г.Ганбаатар аудитор П.Мөнхтуяа нар хийж гүйцэтгэлээ.

7. Ерөнхий мэдээлэл:

Монгол улсын 2010-2016 оны төсвийн тухай хуулиудад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх төсөл арга хэмжээний жагсаалтанд батлагдсан боловч санхүүжилт нь зогсож, барилга угсралтын ажил бүрэн дуусаагүй, улсын комисст хүлээлгэн өгөөгүй, 3613.7 сая төгрөгний төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээний барилгын ажил байна. Үүнд:

Тэшиг суманд баригдаж байгаа бүрэн дунд сургуулийн 240 хүүхдийн суудалтай өргөтгөлийн барилгын ажлыг Орхон аймгийн “Төмөр хүлэг” ХХК 218.2 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр 2011 оны 10 дугаар сарын 17-нд 17/2011 тоот гэрээ байгуулан ажлыг эхэлсэн, БСШУЯамтай дахин барилгыг 2012 оны 11 дүгээр сарын 06-нд ашиглалтанд өгөхөөр 531.8 сая төгрөгний өртөгтэй 17/2011-61 тоот гэрээ байгуулсан ажил дуусаагүй, 2013 онд ажил хийгээгүй, авсан санхүүжилт тодорхойгүй, 2014-2015 онд уг барилгын санхүүжилтийг царцаасан 2016 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 78.0 сая, Векселиэс мөн 78.0 сая төгрөг нэмж санхүүжилт авсан боловч 156.0 сая төгрөгний ажил хийгдээгүй, ажлын гүйцэтгэл тодорхойгүй байгаа, одоо хүртэл ажил дуусаагүй байна.

Булган сумын 1-р сургуулийн өргөтгөлийн 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилга угсралтын ажил 2.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, анх БСШУЯ-наас тендер зарлаж Улаанбаатар хотын “Зоос трейд” ХХК шалгарч 1849.0 сая төгрөгөөр барьж 2013 оны 8 сард ашиглалтанд өгөхөөр гэрээ байгуулсан нийт 2057.0 сая төгрөгний санхүүжилт авсан, ажил дуусаагүй байна.

А.1.Төсөл арга хэмжээний төлөвлөлт хуулийн шаардлагад нийцсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2011 оноос Булган аймагт хэрэгжиж байгаа 3613.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээг 2010 оноос орон нутгаас санаачлан сургуулийн хүчин чадал хүүхдийн суудлын тоог нэмэгдүүлэх, сурах орчинг сайжруулах, үйлчилгээг нэмэгдүүлэх, урлаг соёл, спортын үйлчилгээг иргэдэд хүргэх нэмэгдүүлэх зорилгоор аймгийн хөгжлийн цогц бодлого болон салбарын бодлоготой уялдуулж, төсөл арга хэмжээ нь ТЭЗҮ-тэй, зураг төсөл хийгдсэн хуулийн шаардлага хангасан хөрөнгө оруулалтын ажлуудын төлөвлөлтийг үндэслэлтэй хийж орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн байна.

А.2. Захиалагчийн болон зохиогчийн хяналтыг барилга угсралтын ажлын явцад үр нөлөөтэй хэрэгжүүлээгүй, ажлын гүйцэтгэлийг хугацаанд нь бодитой үнэлж, баталгаажуулаагүй байна.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдан хэрэгжиж байгаа дуусаагүй Булган сумын 1-р сургуулийн 640 хүүхдийн суудалтай өргөтгөлийн барилгын ажилд захиалагчийн хяналтыг гэрээний дагуу аймгийн ГХБХБГ хяналт тавьсан, БСШУСЯ-наас хяналт тавиагүй, зохиогчийн хяналтыг “Өлзий иш” ХХК хяналт хийгээгүй байна.

Орхигдсон Тэшиг сумын 240 хүүхдийн суудалтай өргөтгөлийн барилга угсралтын ажилд аймгийн ГХБХБГ 2012 он хүртэл захиалагчийн хяналт тавьсан 2013 оноос хойш хяналт тавиагүй зохиогчийн хяналтыг “Голомт өргөө” ХХК хяналт тавиагүй, Захиалагчийн болон зохиогчийн хяналтыг хангалтгүй хэрэгжүүлж байна.

А.3. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд талуудын хүлээх эрх, үүрэг, хариуцлагыг бүрэн тусгасан боловч гэрээгээр хүлээсэн үүргээ 2 тал хэрэгжүүлээгүй байна.

Тэшиг сумын бүрэн дунд сургуулийн 240 хүүхдийн суудалтай өргөтгөлийн барилгын ажил 750.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, тендерийг БСШУЯ-аас 2011 онд зарлаж Орхон аймгийн “Төмөр хүлэг” ХХК шалгарч ажлыг гүйцэтгэх 2011 оны 10 дугаар сарын 17-ны 17/2011 тоот гэрээ байгуулж 2013 оны 03 сарын 06-нд ашиглалтанд оруулахаар гэрээнд тусгасан, БУ-2011/17+2 тоот гэрээгээр ашиглалтанд оруулах хугацааг 2013 оны 08 сарын 15-ны өдөр гэж өөрчилсөн, гэрээнд талуудын хүлээх эрх, үүрэг, хариуцлагыг бүрэн тусгасан боловч гэрээгээр хүлээсэн үүргээ 2 тал хэрэгжүүлээгүй байна.

А.4. Гүйцэтгэгч байгууллага барилга угсралтын ажлыг батлагдсан зураг төсөл, барилгын норм дүрмийн дагуу гүйцэтгээгүй байна.

Тэшиг сумын бүрэн дунд сургуулийн 240 хүүхдийн суудалтай өргөтгөлийн барилгын хийцэд гарсан алдааны талаар “Реконстракшн” төвөөс дүгнэлт гарч тогтворжилт хангах тул нэмж хүчитгэх шаардлагагүй гэсэн дүгнэлтийг гаргасан, барилгын ажлыг зураг төсөв, барилгын норм дүрмийн дагуу хугацаанд хийж гүйцэтгээгүй байна

А.5. Ажлын гүйцэтгэл тодорхойгүй байхад санхүүжилт олгосон байна.

Тэшиг сумын сургуулийн 240 хүүхдийн өргөтгөлийн барилгын ажлыг хийж гүйцэтгэж байгаа Орхон аймгийн “Төмөр хүлэг” ХХК нь жил бүр тодорхой хэмжээний

санхүүжилт авсан 2011 онд 250.0, 2012 онд 300.0 сая төгрөгийн санхүүжилт авсан боловч барилгын ажлын санхүүжилт аймгийн төрийн сангаар дамжаагүй, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд 78.0 сая төгрөгний санхүүжилт авсан, **Векселиэр** ажлын гүйцэтгэл гаргаж банкнаас бэлнээр 78.0 сая төгрөг нэмж давхар авсан орон нутагт ирж ажиллаагүй, ажлын гүйцэтгэл тодорхойгүй, ажлын гүйцэтгэлтэй уялдуулан санхүүжилтийг оновчтой хувиарилж олгоогүй байна.

А.6. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг захиалагчийн хяналт муутай, гүйцэтгэгч үүргээ биелүүлээгүй байхад олгосон байна.

Булган сумын 1-р сургуулийн 640 хүүхдийн суудалтай өргөтгөл, Тэшиг сумын бүрэн дунд сургуулийн 240 хүүхдийн суудалтай өргөтгөлийн барилгын ажилд жил бүр санхүүжилт авсан боловч олон жил он дамжин хэрэгжиж байгаа ажил нь дуусаагүй нийт 3613.7 сая төгрөгний төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээний барилга угсралтын ажил удааширалтай байна. Үүнд:

Булган сумын 1-р сургуулийн 640 хүүхдийн суудалтай барилга.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Булган сумын 1-р сургуулийн өргөтгөлийн 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын ажил 4300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилгын тендерийг БСШУЯ-аас зарлаж “Оффис констракшн” ХХК шалгарч 2014 оны 08-р сарын 22-ны өдрөөс 2016 оны 03-р сарын 30-нд барьж дуусгахаар гэрээ байгуулсан хугацаа хэтэрсэн. **2013-2015 онд**

2015 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 558.6 сая төгрөгний санхүүжилт олгосон ажлын гүйцэтгэл тодорхойгүй байсан.

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 2-р хавсралтаар доорхи санхүүжилтыг авсан. Үүнд:

XI.1.1.34. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд 1207.9 сая төгрөгний санхүүжилт олгосон мөн,

X.1.1.24. Векселиэр мөн 2016 онд ажлын гүйцэтгэл гаргаж банкнаас бэлнээр 214.3 сая төгрөг нэмж давхар авсан ажлын гүйцэтгэл тодорхойгүй, орон нутгийн ГХБХБГ-аас тодорхой хяналт тавиагүй нийт ажлын гүйцэтгэл тодорхойгүй байсан.

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн 2-р хавсралтаар доорхи санхүүжилтыг авсан. Үүнд:

X.1.1.13. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд 800.0 сая төгрөгний санхүүжилт олгосон ажил график төлөвлөгөөний дагуу хийгдэж барилга угсралтын ажил нь каркасны ажил 100% дууссан бөгөөд гадна ханын дүүргэлт, дотор, гадна шавардлага, гадна шугам сүлжээний ажил хийгдээд байна. Гэрээнд өөрчлөлт оруулж 2017 оны 08-р сарын 20 хүртэл сунгасан ажил дуусаагүй, 2018 онд гэрээ сунгагдаагүй, ажил эхлээгүй байна. Аймгийн ГХБХБГ-аас барилгын ажилд хяналт тавьж нийт ажлын гүйцэтгэл 75 хувьтай байна.

Яам тухайн жилд олгосон санхүүжилтийг ажлын гүйцэтгэлтэй тулган, мэргэжлийн байгууллагатай хамтран шалгаж дараа оны мөнгийг олгож байх шаардлагатай байна.



/Булган сумын 1-р сургуулийн 640 хүүхдийн суудалтай барилга. 2016 он 12 сар



/Булган сумын 1-р сургуулийн 640 хүүхдийн суудалтай барилга. 2017 он 12 сар

Тэшиг сумын сургуулийн 240 хүүхдийн өргөтгөлийн барилга:

Тэшиг сумын бүрэн дунд сургуулийн 240 хүүхдийн суудалтай өргөтгөлийн барилгын ажил 750.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, сонгон шалгаруулалтыг БСШУЯ-аас 2011 онд зарлаж, тендерт Орхон аймгийн “Төмөр хүлэг” ХХК шалгарч барилгын ажлыг гүйцэтгэх 2011 оны 10 дугаар сарын 17-ны 17/2011 тоот гэрээ байгуулж 2013 оны 03 сарын 06-нд ашиглалтанд оруулахаар гарээнд тусгасан, БУ-2011/17+2 тоот гэрээгээр ашиглалтанд оруулах хугацааг 2013 оны 08 сарын 15-ны өдөр гэж өөрчилсөн боловч ямар ажлыг гүйцэтгэж хэдий хэмжээний санхүүжилт авсан нь тодорхойгүй, яамнаас 2011 онд 250.0, 2012 онд 300.0 сая төгрөгийг дуусаагүй барилгын дансанд бүртгүүлсэн байна. Барилгын ажлын гүйцэтгэл хангалтгүй, аймгийн ГХБХБГ, СТСХ, Боловсрол соёлын газраас тавих хяналт хангалтгүй, мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулахаар ажлыг түр зогсоосон 2013, 2014 онд хэдэн төгрөгийн санхүүжилт авсан нь тодорхойгүй байна.

Тэшиг сумын сургуулийн өргөтгөлийн барилгын үндсэн цутгамал төмөр бетон арагт бүтэцийг цутгахдаа тэнхлэгийн хэмжээ алдсан, гадна ханын дүүргэлтийн хөнгөн блокон өрлөгийн ажил хийгдээд ажил бүрэн зогссон, барилгын ажлын гүйцэтгэл 2014 онд аймгийн ГХБХБГ-аас гаргасан дүгнэлтээр ажлын гүйцэтгэл 45 орчим хувьтай байсан.



2015 он

2016 он

Тэшиг сум сургуулийн өргөтгөлийн барилга

XI.1.1.41. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд санхүүжих дүн 200.0, гүйцэтгэлээр 78.0 сая төгрөгний санхүүжилт олгосон орон нутагт ирээгүй, тодорхой ажил хийгээгүй гэж ашиглагч байгууллага тодорхойлсон байна.

X.1.1.60. Векселиэр ажлын гүйцэтгэл гаргаж банкнаас бэлнээр 78.0 сая төгрөг нэмж давхар санхүүжилт авсан боловч 2016 онд Тэшиг суманд ирж ажиллаагүй, ажлын гүйцэтгэл тодорхойгүй, орон нутгийн ГХБХБГ-аас тодорхой хяналт тавиагүй гэрээний хугацаа дууссан байна. 2017 онд огт ажил хийгээгүй.

Орхон аймгийн “Төмөр хүлэг” ХХК нь ЗТБХБС-ын 2012 оны 18, 181-р тушаалуудын дагуу төсөвт өөрчлөлт оруулж өгөхийг хүссэн, холбогдох байгууллага авч хэлэлцээгүй, гэрээ сунгаагүй байна. Барилга угсралтын ажлын төсвийг Барилга хөгжлийн төвийн магадлалаар оруулж 2017 оны 11 сарын 03-ны өдрийн 82/2017 тоот дүгнэлтээр үлдэгдэл ажлыг 506.8 сая /506778657/ төгрөгөөр шинэчлэн баталгаажуулсан 2018 оны төсөвт 200.0 сая төгрөг тусгуулсан байна.

Бүлэг Б

Тэшиг сумын сургуулийн барилгыг Барилгын хөгжлийн төвийн магадлалаар оруулж 2017 оны 82/2017 тоот дүгнэлтээр барилгын ажлыг үргэлжлүүлэн цаашид ашиглах боломжтой гэсэн. Харин аудитын дүгнэлтээр “Төмөр хүлэг” ХХК нь гэрээний дагуу ажлаа хийгээгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй байна..

Б.1. Дуусаагүй орхигдсон, барилга байгууламжийн хэрэгцээ шаардлага хэвээр байна.

Тэшиг сум нь аймгийн төвөөс 256 км алслагдсан, ерөнхий боловсролын 9 жилийн сургууль нь 320 хүүхдийн хүчин чадалтай, 2010 онд 490 хүүхэдтэй 19 бүлэгтэй сургуулийн хүүхдийн сурах орчин нөхцлийг сайжруулах, хичээлийн байрыг өргөтгөх хэрэгцээ шаардлагыг хангах зорилгоор 2010 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 240 хүүхдийн суудалтай сургуулийн өргөтгөлийн барилгын ажил 750.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барьж байгуулахаар тусгуулан 2011 онд барилгын ажил эхэлсэн боловч одоо болтол дуусаагүй 7 жил болж байна. Одоо Тэшиг сумын 9

жилийн сургууль нь 23 бүлэгт 598 хүүхэдтэй хичээллэж байгаа хэрэгцээ 2 дахин нэмэгдсэн, хичээлийн байрны хангамж муутай зайлшгүй хэрэгцээ шаардлага хэвээр байна.

Булган сумын ерөнхий боловсролын 1-р сургуулийн 920 хүүхдийн хичээлийн байр цаашид ашиглах боломжгүй гэсэн мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарч улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 640 хүүхдийн суудалтай өргөтгөлийн барилгын ажил тусгагдсан, одоо 45 бүлэгт 1080 хүүхэд хичээллэж байна.

Б.2.Дутуу орхигдсон барилгын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх замаар цаашид ашиглах боломжтой гэсэн дүгнэлтийг Барилгын хөгжлийн төвөөс гаргасан байна.

Тэшиг сумын бүрэн дунд сургуулийн 240 хүүхдийн суудалтай өргөтгөлийн барилга угсралтын ажлын төсвийг Барилга хөгжлийн төвийн магадлалаар оруулж 2017 оны 11 сарын 03-ны өдрийн 82/2017 тоот дүгнэлтээр барилгын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж цаашид ашиглах боломжтой гэж мэргэжлийн байгууллага шийдвэрлэсэн байна.

Орхон аймгийн “Төмөр хүлэг” ХХК нь цаашид барилгын ажлыг үргэлжлүүлэн хийхэд хүндрэлтэй, ашиглагч байгууллагатай хамтарч ажилладаггүй гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй байна.

Б.3.Барилгын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх шаардлагагүй гэж дүгнэсэн барилга байгууламж байхгүй боловч, олон жил удааширсан, ажилд холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Тэшиг сумын 240 хүүхдийн суудалтай сургуулийн өргөтгөлийн барилгын ажил 2011 онд барилгын ажил эхэлсэн боловч одоо болтол дуусаагүй 7 жил болж байхад хуулийн дагуу хариуцлага тооцоогүй байна.

Гэрээний үүргээ биелүүлээгүй, ямар ч хариуцлага тооцоогүй, зураг дээр ямар ажил хийсэн, ямар материал орсон тодорхой байхад хариуцлага тооцоогүй, өнгөрсөн хугацаанд гэрээний дагуу ажиллаа хугацаанд нь хийсэн бол улсын төсөвт нэмж 506.8 сая төгрөг тусгахгүй, дахин зардал гаргахгүй байх боломж байсан.

Дүгнэлт:

- Орхон аймгийн “Төмөр хүлэг” ХХК-ний барьж байгаа Тэшиг сумын сургуулийн 240 хүүхдийн өргөтгөлийн барилгын ажил 2013, 2014 онд зогссон, 2016 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 78.0, Векселиэр ажлын гүйцэтгэл гаргаж банкнаас бэлнээр 78.0 сая төгрөг нэмж давхар авсан боловч ажил хийгээгүй, өнгөрсөн хугацаанд гэрээний дагуу ажиллаа хугацаанд нь хийж гүйцэтгээгүй, захиалагчийн хяналт хангалтгүй, хуулийн дагуу хариуцлага тооцоогүйгээс улс, орон нутагт хохирол учруулсан байна.

- Гүйцэтгэгч байгууллага төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж чадаагүй, орон нутагт эрх шилжиж ирээгүй, мэргэжлийн байгууллага, БСШУЯ-аас ажлын гүйцэтгэлд хяналт хангалтгүй тавьсан.

-Аймагт хэрэгжиж байгаа улсын төсвийн хөрөнгө оруулалт нь сум, орон нутгийн Эрүүл мэнд, Боловсролын салбарын зайлшгүй хэрэгцээ шаардлагыг үндэслэн

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

тодорхойлж төлөвлөсөн ч хөрөнгө оруулалтын ажил удаашралтай, гэрээний хугацаанд барилгын ажлыг дуусгаагүй олон жил болсон, гүйцэтгэгч компаниуд гэрээний үүргээ биелүүлдэггүй, санхүүжилтийг ажлын гүйцэтгэлтэй уялдуулж олгодоггүй, санхүүжилт аваад орон нутагт ирж ажилладаггүй зэргээс шалтгаалж барилгын ажил удааширсан.

ТАНИЛЦСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР